

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2022 оны 06 сарын 06-ны өдөр

Дугаар БУ-08/2022

Арвайхээр сум

Нэг. Удиртгал хэсэг

Өвөрхангай аймгийн Богд сумын төвд баригдсан 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/284 дугаар захирамжаар байгуулагдсан 17 хүний бүрэлдэхүүнтэй барилга, байгууламжийг ашиглалтанд оруулах комисс 2022 оны 06 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар – БЭЗ-62-35/21

2.2. Барилга байгууламжийн зураг төсвийн шифр дугаар- КМ-21-16-419

2.3. Барилгын захиалагч: Өвөрхангай аймгийн ЗДТГ, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар-000042543, Хаяг: Арвайхээр сум, 5-р баг, Нутгийн удирдлагын ордон, утас-70322293

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Дуутын нуруу", Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:9011454128, Регистрийн дугаар: 5801265, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: БУ16-604/17, Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 17-р хороо, 67-897В, Холбоо барих утас: 88119794, Цахим шуудан: duutiin_nuruu@yahoo.com

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэх байгууллага: байхгүй

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Кретив монголиа" ХХК, Зургийн шифр: 5726824, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011419094, Регистрийн дугаар: 5726824, Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: ЗТ11-582/17, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, 69-84 тоот, Холбоо барих утас: 99114527, Цахим шуудан: enhjinodnoo1@gmail.com

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Богд сумын Эрүүл мэндийн төв, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар-1011005066, Регистрийн дугаар- 9044418 хаяг: Өвөрхангай аймаг, Богд сум, 7-р баг, утас: 91066747

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал:

Эмнэлгийн барилга байгууламж нь тэнхлэгээрээ 20х15м хэмжээтэй, 2 давхар, төмөр бетон цутгамал арагт бүтээцтэй, гадна хана нь 360мм хөнгөн блокон хана, 15 см-ийн хөөсөн дулаалгатай, хавтгай дээвэртэй барилга.

Гадна дулаан, хэрэглээний халуун, хүйтэн ус: Дулааны шугамыг зүүн талаас 28м газар 3 шугамыг 50мм-н голчтой ган хоолойг шилэн хөвөнгөөр дулаалж 1,5м гүнд сувагчлал хийн ДХ-27-р худгаас огтолгоо авч угсарсан. Хэрэглээний халуун, хүйтэн усны шугамыг 50мм-н цайрдсан ган хоолойгоор угсарсан. Сувагчлалын ханыг 600мм-н блокоор өрж, тагийг бетон тагаар хийсэн.

Бохир усны шугам: Барилгаас чанх урагш 5метрт 1000 диаметр бүхий угсармал төмөр бетон хяналтын худаг гаргаж, Тус худгаас шугамыг баруун тал руу 34м газар 160мм-н хуванцар хоолой ашиглан, шилэн хөвөнгөөр дулаалж 1.7-2.м гүнд, эмнэлэгийн хуучин худагт угсарсан.

Гадна цахилгаан: Гадна цахилгааныг АВВГЗх50+1х25 маркийн хос кабелиар 100м газар 0,7м гүнд элсэн дэвсгэр хийж, тоосгоор хучин булсан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

3.1. Энэхүү 2-р ангиллын Өвөрхангай аймгийн Богд сумын төвд баригдсан 15 ортой Эрүүл мэндийн төвийн барилга байгууламжид, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос

ДҮГНЭСЭН нь:

Энэхүү барилга, байгууламжийн угсралтын ажил нь зохих зөвшөөрөл зураг төслийн дагуу баригдсан гэж үзээд ашиглалтанд оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

А) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

Б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

А) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

Б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

В) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 2 хуудас, хуралдааны тэмдэглэл хуудас, материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Энэхүү 2-р ангиллын Өвөрхангай аймгийн Баянгол сумын төвд баригдсан Усны даралтын цамхагийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга:  Т.Ариунболд /ГХБХБГазрын дарга /

Нарийн бичгийн дарга:  С.Мөнх-Эрдэнэ /ГХБХБГазрын БХБХэлтсийн мэргэжилтэн

 Г.Чулуунбаатар /"Дуутын нуруу" ХХК-н дарга/

(Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй)

--o0o--